



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 142,486,650 (нэг зуун дөчин хоёр сая дөрвөн зуун наян зургаан мянга зургаан зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 20,700,460 (хорин сая долоон зуун мянга дөрвөн зуун жаран) төгрөгийн элэгдэл бүхий Хүүхэд залуудуудын хөгжлийн төвийн барилгыг доорх газрын хамт Шүүхийн шинжилгээний албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэн, аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дарга Б.Нарантуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 01-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР